



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/549

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "в", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дугаар зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар албан даалгавар /Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажил хангах/-ыг хэрэгжүүлэх, коронавируст халдвар тархалтын үед иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор Голомт банкнаас Төрийн банкны зээлийн төв хүртэлх дулааны шугам шинэчлэхэд 13 000 000, УДДТ-7-г иж бүрэн тоноглоход 30 574 940, 27 айлын орон сууцны барилгын гаднах дулааны шугам шинэчлэхэд 6 196 000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрхи арга хэмжээнүүдэд зарцуулах 49 770 940 төгрөг /дөчин есөн сая долоон зуун далан мянга есөн зуун дөч/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.8. Хуучирч муудсан шугам сүлжээний засвараас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Төсөл арга хэмжээний захиалагчийн техникийн хяналт хийж тайлагнахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/, Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/ нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ